

ТҮВШИНШИРЭЭ СУМЫН 2023 ОНЫ 7 ДУГААР САРЫН АЖЛЫН ТОВЧ МЭДЭЭ

Төрийн удирдлагын чиглэлээр:

Тулгар төрийн 2232 жил, Их Монгол Улс байгуулагдсаны 817 жил, ардын хувьсгалын 102 жил, Түвшинширээ сум үүсгэн байгуулагдсаны 98 жилийн ойн баяр наадмыг сумын Засаг даргын 2023 оны А/81 захирамжаар 7 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд зохион байгууллаа. Баяр наадмын комисс 5 салбар комисстойгоор томилогдож бэлтгэл ажлыг ханган ажиллалаа.

Баяр наадмаар нийт 245 хурдан морь уралдаж, 64 бөх барилдаж, 28 харваачид цэц мэргэнээ сорилоо. Давхардсан тоогоор нийт 73 хүүхэд хурдан морь унаж уралдсан байна. Уралдааны замд мориноос унасан, гэмтсэн хүүхэд байхгүй. Уяач болон унаач хүүхдүүдийг системд бүртгэж, уяач хамаатан садны болон хөлсөөр морь унуулж байгаа тохиолдолд унаач хүүхдүүдийн эцэг эх, асран хамгаалагчтай гэрээ болон зөвшөөрөл байгуулж ажиллалаа. Мөн бүртгэл хийлгэж байгаа унаач хүүхэд бүрд унаач хүүхдийн мандат олгосон бөгөөд Хүүхэд хамгааллын хамтарсан багаар уяач, унаач хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч нарт зөвлөгөө мэдээлэл өгч унаач хүүхдийн хамгаалалтын хувцасны стандарт болон Хүүхэд хамгааллын тухай хуулийн брошур тараасан. Үндэсний их баяр наадмын тухай хууль шинэчилсэн найруулгаар хурдан морины уралдаанд уралдах морийг найм, түүнээс дээш насны хүүхэд унаж уралдах хэмээн тусгасныг мөрдөж ажиллалаа. Мөн унаач хүүхдийн аюулгүй байдлыг хандах үүднээс стандартын шаардлага хангасан хувцас хэрэглэл өмсгөж, гэнэтийн ослын даатгалд заавал хамрагдсан байх зэрэг шаардлагуудыг тавьж ажилласан.

Уралдааны замд гарах морьдын сэрвээний өндрийг хэмжиж мордуулсан бөгөөд хэмжилтэнд оруулж, хэмжилтэнд тэнцээгүй морьдыг хассан.

Мөн баяр наадмын хөтөлбөрт уурга шүүрэх, үндэсний шагайн харваа, 10-12 настай хүүхдийн барилдаан зэрэг уралдаан тэмцээн зохион байгуулж, нийт 142 хүн хамрагдсан байна.

Төсөв санхүүгийн чиглэлээр:

Сар бүрийн 8-ны дотор шилэн дансанд байгууллагуудын сарын төсвийн гүйцэтгэл, орон нутгийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэл, ОНХСангийн төлөвлөгөө гүйцэтгэл бусад мэдээ мэдээллийг шивж байна.

Нийгмийн даатгалын НД 8, НД7 /ажиллагсдын цалин тооцооны хуудас/ тайлангууд мөн татварын ТТ 11, ТТ 12 буюу үндсэн цалин, хөдөлмөрийн хөлс

болон түүнтэй адилтгах орлогоос суутган тооцсон татварын тайлангуудыг гарган интернетэд шивэн цахимаар илгээсэн.

Төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нар байгууллагуудын 2024 оны төсвийн төсөл, 2023 – 2025 оны төсвийн төсөөллийг хийж хариуцсан мэргэжилтэнд тушааж программд шивж илгээсэн. Орон нутгийн хөгжлийн сангаар 2024 онд хийгдэх ажлуудын санал асуулгыг багийн Засаг дарга нар эрэмбэлэн УМС-д шивж байна.

Хөрөнгө оруулалт, Дэд бүтэц, Байгаль орчин, Хөдөө аж ахуйн чиглэлээр:

Мал сүрэгт халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх 8 төрлийн вакцинжуулалт хийгдэхээс листериоз 14305, цусан халдварт 7957, шөвөг яр 460, боом 319, галзуу 1311, нийт 24352 толгой малд вакцинжуулалт хийж цахим системд оруулсан байна.

Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 5 багийн 498 өрхийн 18681 үхэр хамрагдаж цахим системд орж баталгаажсан байна.

Мал эмнэлгийн цахим системд 9 дуудлага бүртгэгдсэн байна. Мөн эрт илрүүлэгийн үзлэг тандалт 29 өрхийн бод 271, бог 394 толгой мал үзлэгт орсон байна. 2023 он гарсаар 370 ш гарал үүслийн гэрчилгээ бичигдсэн байна.

Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын дараах мониторингийн ажлыг Таван хөөрхөн мал эмнэлэгтэй хамтран хийж 2 багийн 3 өрхийн 16 үхрээс цус авч авч аймгийн мал эмнэлэгт хүргүүлсэн.

Мал төллөлтийн ХАА-1 мэдээ, Том малын хорогдлын ХАА -2 мэдээг өрх тус бүрээр нь гаргаж , статистикийн программд шивж оруулсан.

ХАА -3 хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн мэдээ, ХАА-6 хүнсний ногоо тариалсан талбайн мэдээг шивж оруулсан.

Аймгийн төрийн аудитын газраас Зах зээл ба бэлчээр удирдлагын хөгжил төслөөр хийгдсэн ажил хяналт шалгалт хийлээ. Уг төслөөр тус сумын Өгөөмөр, Үнэгт багуудад 2020 онд баригдсан мал угаалгын ванн чанарын шаардлага хангахгүй байгаа тул сумын Засаг даргын албан бичиг төрийн аудитын газарт явуулсан.

Хоршоо хөгжүүлэх сангийн найдваргүй 6 зээлдэгчийн мэдээллийг аймгийн Хоршоо хөгжүүлэх сан руу хүргүүлж, нийт зээл авсан иргэд болон аж ахуй нэгжүүдтэй уулзаж, зээлээ хугацаанд нь төлөх талаар сануулж ажиллалаа.

Сүхбаатар аймгийн эрүүл мэндийн газрын улсын байцаагчийн 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 383 тоот “Баяр наадмын үеэр үйл ажиллагаа явуулж буй хүнсний худалдаа, хоол үйлдвэрлэл үйлчилгээ явуулах иргэдэд хүргэх зөвлөмж”-ийн дагуу сумын баяр наадмын үеэр тус чиглэлээр үйл ажиллагаагаа явуулах иргэдэд зөвлөмж хүргүүлж заавар зөвлөгөө өгч ажиллалаа. Тус ажлын хүрээнд зөвшөөрөл авсан хуушуурын 7 гэр, тоглоом, хүнс худалдааны 6 газарт улсын байцаагчийн зөвлөмж дээр заасан шаардлагын дагуу үйл ажиллагаагаа явуулж ажиллах чиг өгсөн боловч баярын үеэр хяналт шалгалт хийхэд зөвлөмжийн дагуу үйл ажиллагаагаа явуулсан газар байхгүй байсан ба хоол үйлдвэрлэлийн үйлчилгээ явуулах иргэд эрүүл мэндийн урьдчилсан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамрагдсан дэвтэр байхгүй, зориулалтын усны сав болон ус муудах, бохирдох эрсдэлийг тооцож угаалга цэвэрлэгээний бүртгэл хөтлөөгүй, дотоод хяналт зохион байгуулалтгүй, хоол үйлдвэрлэлд хэрэглэж буй түүхий эд, бараа бүтээгдэхүүний эрүүл ахуйн аюулгүй үзүүлэлтийн шинжилгээ, баталгаажилтын баримт байхгүй байсан зэрэг маш олон зөрчил гарсан. Уг зөрчил гаргасан үйлчилгээ явуулж байгаа иргэдэд зөрчилийг газар дээр нь арилгуулах арга хэмжээ авч ажилласан.

Нийгмийн халамж, хөдөлмөр эрхлэлт, Боловсрол, Соёл, Эрүүл мэндийн чиглэлээр:

СОЁЛЫН ЧИГЛЭЛЭЭР: Сум байгуулагдсаны 98 жилийн ойн баяр наадмын урлагийн тоглолтын арга хэмжээнд зориулан “Дарьгангын чимэг” бүжгийг бэлтгэн наадамчин олонд хүргэсэн.

Тус сумын Соёлын төвийн дуу хөгжмийн багш СТА-н Л.Гантулга “Удам дамжсан аялгуу” анхны бие даасан тоглолтоо толилууллаа.

Хүүхдийн хөгжил хамгаалалыг дэмжих жилийн ажлын хүрээнд байгууллагын албан хаагчдын хүүхдийн өрөөг шинээр тохижууллаа.

Чингис хааны музейтэй байгуулсан “Эзэнт гүрний өв соёл” төсөл хамтран ажиллах гэрээний хүрээнд орон нутаг судлах танхимд витриныг шийдэж өгснийг хүлээн авч байршуулах ажлыг хийж гүйцэтгэн ажиллаж байна.

Номын сан нь 2023 онд хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа хүргэн ажиллаж байна. Номын сангаар нийт 22 уншигч үйлчлүүлж, 41 номыг олгосон.

Соёлын төв нь БОЛОВСРОЛ, СОЁЛ-ын хөтөлбөрын хүрээнд оюутан залуустай хамтарсан “Хамтдаа хөгжье” хөтөлбөр сургалтыг 3 оюутан залуустай

хамтран хичээллэж байна. Уг хөтөлбөрт нийт 40 сурагч хамрагдан суралцаж байна.

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР: Эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаа нь жигд хэвийн явагдаж байна. Амбулаторийн нийт үзлэг 275, алсын дуудлага 7, гэрийн дуудлага 13, хэвтэн эмчлүүлэгч 19, халдвартай бүсэд хэвтэн эмчлүүлж байгаа өвчтөн-1.

Товлолын вакциныг 60 хүүхдэд хийсэн байна.

Тус эрүүл мэндийн төвийн сэргээн засах эмчилгээнд бумба-12, гэрэл эмчилгээ-9, бариа засал-16 иргэн тус тус хамрагдсан.

Тухайн сард Лабораторын хийсэн шинжилгээ үйлчилгээ: сахар – 12, шээсний ерөнхий шинжилгээ – 23, ковид -17, элэгний В, С вирусын шинжилгээ – 6, үе мөч-9, БЗХӨ-5, бруцёллёз-5 хүн тус тус хамруулаад байна.

Тайлан нэгтгэсэн:

ХЭЗХМэргэжилтэн

Ш.Дүүрэнбилэг

Хянасан:

Тамгын газрын дарга

Ц.Ренчинмядаг